



УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК

**“10/0.4 кВ иж бүрэн КТПН (трансформаторгүй)“ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Тендерийн нэр: 10/0.4 кВ иж бүрэн КТПН (трансформаторгүй)
Тендерийн дугаар: ХА-043/2020

Улаанбаатар хот

ЦАХИМ ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Тендерийн нэр: “10/0.4 кВ иж бүрэн КТПН (трансформаторгүй)“ нийлүүлэх
Тендерийн дугаар: ХА-043/2020

“УБЦТС” ТӨХК эрх бүхий тендерт оролцогдоос “10/0.4 кВ иж бүрэн КТПН (трансформаторгүй)“ нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /тавин мяняган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 09 цаг 30 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10 цаг 00 минутад тендерийн нээлтийн өрөөнд нээнэ. /УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 45.
УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж үйлчилгээний алба
Утас: 342420 +157, Факс: 976-341852
Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	Захиалагч нь: "УБЦТС" ТӨХК
ТОӨЗ 1.1	Тендерийн нэр дугаар: 10/0.4 кВ иж бүрэн КТПН (трансформаторгүй) ХА-043/2020
ТОӨЗ 1.1	<p>1. Сүүлийн /2019 он/ нэг жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан ирүүлнэ.</p> <p>2. Сүүлийн нэг жилийн /2019 он / борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгийн 80%-с багагүй</p> <p>3. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр нийлүүлсэн барааны гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн актын хуулбар ирүүлэх/</p> <p>Бусад нэмэлт шаардлага:</p> <p>4. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга.</p> <p>5. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын"-ын дагуу "татвар төлөлт, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана".</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 09 цаг 30 минутаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 04 дугаар сарын 08-ны өдрийн 10 цаг 00 минутад тендерийн нээлтийн өрөөнд нээнэ./УБЦТС ТӨХК-н төв байрны 206 тоот/</p> <p>Захиалгчийн хаяг:</p> <p>Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг. 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө 45. УБЦТС ТӨХК-ийн төв байр. 206 тоот. Хангамж үйлчилгээний алба Утас: 342420 +157,</p> <p>Цахим хаяг: www.tender.gov.mn</p>

ТОӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээ 2. Үнийн саналыг маягтын дагуу ирүүлэх /Бараа нийлүүлэх хугацааны хамт/ 3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолтыг ирүүлнэ. 4. Гэрээний үнээр, захиалгын хугацаанд техникийн шаардлага хангасан барааг хүлээлгэж өгөхийг баталсан албан мэдэгдэл ирүүлнэ 5. Тендерт оролцогч санал болгож буй барааг нь захиалгчийн техникийн даалгаврын шаардлагыг бүрэн хангаж байгааг нотлох зорилгоор тендерийн материалыд үйлдвэрлэгчийн нэр, дэлгэрэнгүй зураг тайлбар, үндсэн үзүүлэлт болон холбогдох бусад холбогдох бичиг баримтыг ойлгомжтой байдлаар бэлтгэж ирүүлнэ. 6. Дотоодын болон олон улсын чанарын стандартын шаардлага хангасан эсэхийг гэрчилэх, сэргификат орчуулж хавсарган ирүүлнэ. 7. Захиалгчийн техникийн шаардлага, нийлүүлэгдэх барааны техникийн тодорхойлолт харьцуулсан ирүүлэх шаардлагатай 8. Тендерийн хэл нь Монгол хэл тул гадаад хэл дээрх материалыг баталгаат орчуулгаар орчуулж ирүүлэх. 9. Шалгарсан тохиолдолд Олон нийтэд мэдээллэхэд татгалзах зүйлгүй тухай албан мэдэгдэл ирүүлнэ, 10. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ. 11. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан материалыудын аль нэгийг үнийн саналд хавсаргаж ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй
ТОӨЗ 18.1 (д)	Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: Чанарын баталгаат хугацаа 6 сар байна.

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
	1	3	4	5	6	7	8
1	10/0.4 кВ иж бүрэн КТПН-400 кВА (трансформаторгүй)	1	ком	УБЦТС ТӨХК төв агуулах	шууд	14-21 хоног	
2	10/0.4 кВ иж бүрэн КТПН-630 кВА (3 ачаалал таслагчтай, трансформаторгүй)	1	ком				
НИЙТ		2					

Барааг шалгаж, хүлээн авах: Нийлүүлж байгаа барааны үйлдвэрлэгчээс олгосон техникийн паспорт, чанарын сертификат, шаардлагатай бусад баримт бичгийн хамт хүлээлгэн өгнө. Нийлүүлэх барааг эрх бүхий байгууллагаар туршилт хийлгэх шаардлага хангаж буй материалтай хүлээн авна. Техникийн паспортгүй, чанарын шаардлага хангаагүй гэж үзсэн барааг захиалагч хүлээн авах үүрэг хүлээхгүй.

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ТРАНСФОРМАТОРГҮЙ ИЖ БҮРДМЭЛ МАЯГИЙН ДЭД ӨРТӨӨ /КТПН/-НД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

Нийлүүлэх КТПН нь Монгол Улсын стандарт MNS 5643:2006 “2-2500 кВА чадалтай, 10 кВ хүртэл хүчдэлтэй иж бүрэн трансформаторын дэд өртөө. Техникийн ерөнхий шаардлага” - ыг хангасан байна. Цахилгаан байгууламжийн дүрэмд заасан тоноглолуудын зайд хэмжээг баримтласан байна.

Санал болгож буй бүтээгдэхүүний бодит зураг, тоноглолуудын техникийн үзүүлэлтүүдийг хавсарган ирүүлнэ.

Кабелийн оруулгатай дэд өртөө КТПН /трансформаторгүй/ нь дараах шаардлагуудыг хангасан байна.

<u>Хүчдлийн түвшин, кВ</u>		
- өндөр талд ӨХ		10
- нам талд НХ		0,4/0,23
Хүчний трансформаторын тоо		1
Хүчний трансформаторын чадал, кВА	400	630
Ачаалал таслагчийн тоо	1	3
Өндөр хүчдэлийн талд цахилгаан динамик гүйдэл, кА,	25 кА-с доoshgүй	
Өндөр хүчдлийн оруулга	Кабель оруулгатай	
Нам хүчдлийн гаргалга	Кабель	
Орчны нөхцөл (У) байрлуулах ангилал (1) ГОСТ 15150-69	У1	
Хэвийн ажлын нөхцөл	Үйлдвэрийн	

КТПН-ийн хийц нь:

КТПН нь хаалтай метал тасалгаатай, 1.5мм-с багаггүй зузаантай ган хуудсаар хийгдсэн байна. Хаалганууд нь түгжээтэй, нугастай, мөн цоожтой байна. Доторх модулууд нь их биенд гагнагдсан байна. Хана нь ган хуудсаар хийгдсэн байх ба хаалга ба салхивчны торыг зэвэрдэггүй гангаар хийж полимер нунтаг будгаар бүрхэж будсан байна.

- КТПН дотор 400, 630 кВА трансформатор суурилагдсан байхаар гүйдэл дамжуулагч, тусгаарлагын хийц тоноглолууд сонгогдсон байна.
- Нам хүчдлийн талдаа 6-аас доoshgүй гаргалгатай байна. /Зураг харна уу/
- Тоолуур болон гүйдлийн трансформаторыг тусдаа цоож бүхий хайрцаг дотор байрлуулна.
- 0.4 кВ хуваарилах самбарын хийц болон хэлбэр хэмжээг “1000В хүртэлх хүчдэлд ажиллах цахилгаан хүчний хуваарилах самбар” техникийн шаардлагын тодорхойлолт /ТШТ: 0.4ХС/-ын дагуу хийж гүйцэтгэнэ.
- Трасформаторын оролт нь шин эсвэл кабелиар байх ба, 0.4 кВ оролт нь шин байна.
- КТПН-д суурилагдах тоолуурууд нь “ТШТ: ТООЛ 220В, 380В, 100В-ын тоолуур” техникийн шаардлагуудыг хангасан байна.
- Бүх тоноглолууд нь зурагт заасантай ижил маркийн тоноглолууд байна.

- Нам талын хуваарилах самбарт гал хамгаалагч, рубильник байна. Мөн гүйдлийн трансформатор, тоолуур, гэрэлтүүлгийн удирдлагын блок, хэт хүчдэл хязгаарлагч, шин байна.

Ашиглалтын нөхцөл


ГОСТ 15150-69 “Машин, багаж хэрэгсэл болон бусад техник эд зүйлс. Цаг уурын янз бүрийн бүсэд зориулсан хийцүүд. Гадаад орчны цаг уурын нөлөөллийн хүчин зүйлээр ангилагдсан ашиглалт, хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөлийн ангилал.” стандартаар тодорхойлогдсон ангилалаар У1 нөхцөлд суурилагдан ашиглагдахаар байх ёстай. Орчны төрөл нь дээрх стандартын ангиллаар II төрөл буюу “үйлдвэрлэлийн” байх болно.

Орчны нөхцөл

Гадна орчны температур, далайн түвшнээс дээш өргөгдсөн хэмжээ, чийгшилт болон бусад өгөгдлүүдийг “ТШТ: ЕШН Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн “24.Орчны нөхцөл” заалтаас харна уу.


КТПН, түүний тоноглолууд нь нь “**ТШТ: ЕШН** Техникийн ерөнхий шаардлага ба нөхцөл”-ийн суурь норматив баримт бичгүүд дээр заасан бүх заалтыг мөрдсөн байх ёстай.

10 кВ-ын хийдээрээх бүрчүүлийн	
	10 кВ-ын төгсгүүлийн шүтэг 3 КНТп
	10кВ-ын Ачилолт пасын ВНА-10/400 /газардлалын хүргөлтэй/
	10 кВ-ын хэмт хүчээл хязгаарлаж Гол хамгаалж: ПКТ-102-10-10-3093
	Хөнгөн цагсан шин АДЭЛТ-40х4
Трансформатор	
	10/0.4 кВ-ын 400 кВА чадалтой С11-М-400/10 ногийн хүчин трансформатор Ук<4.0 %
	Хөнгөн цагсан шин АДЭЛТ-60х4 0-ын шин АДЭЛТ-60х4
	0.4 кВ-ын хэмт хүчээл хязгаарлаж
0.4 кВ-ын хийдээрээх бүрчүүлийн	
	0.4 кВ-ын орлогын солтодур 630 А
	Гүйдлийн трансформатор 600/5 А
	3 фазын электрон тооцуй, 5 А актн реактив чадлын RS зоргалгатай
	Гол хамгаалж 630А
	Хөнгөн цагсан шин АДЭЛТ-60х4
	Хөнгөн цагсан шин АДЭЛТ-60х4
	0.4 кВ-ын гол хамгаалж бүхий рудильник 400A
	0-ын шин АДЭЛТ-40х4
	0.4 кВ-ын кобель шүгэн



Тр-рын чадол, кВА	Тр-рын 0.4 кВ -ын хийдийн шүүгэл, А	Гол хамгаалжийн табил, А							
		1-р шүгэн	2-р шүгэн	3-р шүгэн	4-р шүгэн	5-р шүгэн	6-р шүгэн	7-р шүгэн	8-р шүгэн
400	578	250	250	250	250	160	160		

	ХХХ						
	Цахилгаан холболтын бүдүүвч			Масш 1:			
				Үе шат	Хуудас	Бүх хуудас	
	А.3 1 1						



Применение и материалы изделий	Технические характеристики (мм)							
	Т-Р пружинный	С-Р тканевый	Б-Р тканевый	А-Р тканевый	Б-Р тканевый	С-Р тканевый	Т-Р тканевый	Б-Р тканевый
910	9124	408	422	453	253	273	1022	1022

				XTK
		Циклический кетогенетический Полиурин		Насыщенные Углеводороды
			A3	1 1

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ
1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(*Захиалагч байгууллагын нэр*)-ын дарга _____ танаа

1. Бид, [*төндерт оролцогчийн нэр*] дор дурдсан барааг [*санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр*] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [*тоо*] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гаралт үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|-------------------------------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
|-------------------------------|--|

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 6 сар байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [90] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гарана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Барааг хүлээлгэн өгөхдөө холбогдох эрх бүхий албан тушаалтанд шалгуулж, зөвшөөрлийг авсан байна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> | |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага: Баталгаат засвар, чанарын баталгааны хугацаанд гэрээний үнийн дүнгийн 5%-тай дүйцэхүйц төгрөгийг байршуулна. |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийг барааг хүлээн авсан акт болон гэрээ дүгнэсэн протокол, нэхэмжлэхийг үндэслэн олгоно. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: хоногт гэрээний үниийн дүнгийн 0,1%

Алдангийн нийт дүн: гэрээний үниийн дүнгийн 10% хүртэл |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Төндер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.
Дугаар № [Төндер шалгаруулалт/гэрээний дугаар]

хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн төндерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны ____ дугаар сарын ____ -наас _____ оны ____ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг³;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

² Гэрээ байгуулах үед үүний хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]